



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2021.6.15 № 2/3100
танай _____-ны № _____-т

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Д.НАРАНТУЯА, ЦУС, СЭЛБЭЛТ
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГА
Н.ЭРДЭНЭБАЯР НАРТ

Албан даалгавар өгөх тухай

Улсын онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн тэмдэглэл, 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/262 тоот тушаалаар шинэ коронавируст халдвар (COVID-19)-тай холбоотой судалгаануудыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, шийдвэр гаргагчдыг мэдээлээр хангах зорилго бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Монгол улсад хийгдэх коронавируст халдвар (COVID-19)-ийн судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг баталж, тэргүүлэх чиглэлийн хүрээнд хийгдэх судалгааны сэдэв, удирдагч, санхүүжилт, багийг гарган ажиллаж байна.

Цар тахлын эсрэг биобэлдмэл, вакцин үйлдвэрлэх талаар авах арга хэмжээний талаар Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр танилцуулан тогтоол гарсан.

Монгол Улсын Засгийн Газрын 144 тогтоолоор өгсөн хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэх үүднээс Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн тушаалыг хүргүүлж байна.

Ажиллах удирдамжийн дагуу ажлуудыг эрчимжүүлэх, Монгол Улсын Засгийн Газрын 144 тогтоолын 3,4 дэхь заалтын хүрээнд ажлын удирдамж, цаашид хийх ажлын төлөвлөгөө, санхүүжилтийн тооцоог 2021 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

Холбогдох мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Төрийн нарийн бичгийн дарга



Ц.Эрдэмбилэг

144216465



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 5 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 144

Улаанбаатар
хот

Цар тахлын эсрэг биобэлдмэл, вакцин үйлдвэрлэх
талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв"-ийн "Биобэлдмэлийн үйлдвэр"-т КОВИД-19 цар тахлын эсрэг иммуноглобулин үйлдвэрлэх санхүүжилтэд шаардагдах 284,062,000 (хоёр зуун наян дөрвөн сая жаран хоёр мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсүгэй.

2. "Цус сэлбэлт судлалын үндэсний төв"-д коронавирусын эсрэг сийвэнг бэлтгэх, "Биобэлдмэлийн үйлдвэр"-т КОВИД-19 цар тахлын эсрэг иммуноглобулин үйлдвэрлэх арга хэмжээ авч, 2021 оны III улиралд багтаан эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгасугай.

3. Цаашид гарч болзошгүй цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах зорилгоор "Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв"-ийн дэргэд Коронавирусын эсрэг идэвхгүйжүүлсэн вакцины үйлдвэр, Вакцины хяналтын үндэсний лаборатори байгуулах тооцоо, судалгааг хийж, Засгийн газарт танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

4. Шинэ үеийн биотехнологид суурилсан коронавирусын эсрэг вакцин үйлдвэрлэх технологийг дамжуулан авах ажлыг зохион байгуулахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт, түүнд шаардагдах зардлыг тухай бүр шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын Шадар сайд

С.АМАРСАЙХАН

Сангийн сайд

Б.ЖАВХЛАН



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/340

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 05 дугаар сарын 12 өдрийн 114 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв”-ийн “Биобэлдмэлийн үйлдвэр”-т (КОВИД-19) цар тахлын эсрэг иммуноглобулин үйлдвэрлэх, Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвд коронавирусын эсрэг сийвэн бэлтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Удирдамжийн дагуу нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж, ажлын явцыг Эрүүл Мэндийн Яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөлд тухай бүр танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Эрдэмбилэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга /Г.Ганцэцэг/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141211700

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 сарын 08 -ний өдрийн 17/310 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв”-ийн “Биобэлдмэлийн үйлдвэр”-т (КОВИД-19) цар тахлын эсрэг иммуноглобулин үйлдвэрлэх, Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвд коронавирусын эсрэг сийвэн бэлтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:

Ц.Эрдэмбилэг, Төрийн нарийн бичгийн дарга, АУ-ны доктор, дэд профессор

Нарийн бичгийн дарга:

Э.Оюунсүрэн Эрүүл Мэндийн Яам, Төрийн Захиргааны Удирдлагын Газар, Судалгаа төлөвлөлтийн хэлтсийн эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Б.Буянтогтох, Эрүүл Мэндийн Яам, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Б.Бумдэлгэр, Эрүүл Мэндийн Яам, Төрийн Захиргааны Удирдлагын Газар, Судалгаа төлөвлөлтийн хэлтсийн дарга, АУ-ны доктор

Т.Хонгорзул, Эрүүл Мэндийн Яам, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Д.Нарантуяа, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал, АУ-ны доктор

Ж.Оюунбилэг, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөх, БШУ-ны доктор, профессор

Д.Ичинхорлоо, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн биобэлдмэлийн үйлдвэрийн дарга, АУ-ны доктор

Б.Сайнчимэг, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөх, БУ-ны доктор

Н.Эрдэнэбаяр, Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төвийн захирал, АУ-ны доктор, дэд профессор

Н.Янжиндулам, ЦССҮТ-ийн эрдэм, шинжилгээ, мэдээлэл технологийн албаны дарга

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 сарын 28 -ний өдрийн 11/340 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Ажиллах ажлын удирдамж

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсад коронавируст халдвар (КОВИД-19) илэрсэнээс хойш тохиолдлын тоо нэмэгдсээр одоогийн байдлаар нийт 85770 халдвар бүртгэгдээд байна. Халдварын голомтыг илрүүлж, ойрын хавьтлыг тандах, тусгаарлах үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байгаа боловч халдварын тархалтыг бүрэн хязгаарлаж чадахгүй байна. Тархвар зүйн судалгаагаар цаашид халдварын тархалт ихсэх төлөвтэй байна.

ДЭМБ-ын удирдамжид Коронавируст халдвар (Ковид-19)-аар өвчлөөд эдгэрсэн хүмүүсээс anti-SARS-CoV-2-IgG эсрэг бие агуулсан эмчилгээний сийвэнг бэлтгэн хүнд болон маш хүнд өвчтнүүдийн эмчилгээнд хэрэглэхэд вирусын түвшинг хурдан бууруулж, эмнэлзүйн шинж тэмдэгт эерэгээр нөлөөлж буй талаар олон улсын эрдэмтэн судлаачдын нотолгоо байгааг дурьдсан. Мөн АНУ-ын Цусны Банкуудын Холбоо (AABB)-ны зөвлөмжид энэхүү сийвэнгийн эмчилгээ нь чухал болохыг тэмдэглэн донорыг сонгох, сийвэн цуглуулах, бэлтгэх, түгээх протоколыг батлан хэрэгжүүлж байна.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын тохиолдол эрчимтэй нэмэгдэж байгаа энэ үед цаашид үүсч болох эрсдэлээс сэргийлэх, хүндрэл, нас баралтыг бууруулах зорилгоор манай орны нөхцөл, монгол хүний бие махбодийн онцлогт тохирсон, anti-SARS-CoV-2-IgG агуулсан эмчилгээний сийвэнг бэлтгэх боломжтой байна.

Хүний хэвийн иммуноглобулин нь вирус, бактер, мөөгөнцрийн гаралтай олон өвчний эсрэгбиеийг агуулсан биологийн бэлдмэл бөгөөд дархлаа зохицуулах, сэргээх, дэмжих үйлчилгээтэй тул халдварт өвчнүүдээс сэргийлэх, хүндрэлийг бууруулах, дархлаа сайжруулах зорилгоор олон оронд хэрэглэж байна.

СУДАЛГААНЫ БАГИЙН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг иммуноглобулин үйлдвэрлэх ажлын бэлэн байдлыг хангаж, үйлдвэрлэх
2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг сийвэн бэлтгэх бэлэн байдлыг хангаж, бэлтгэх
3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын олон улсын эмчилгээний удирдамжийг судлан иммуноглобулин болон сийвэнгийн эмчилгээний удирдамжийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах
4. Судалгааны ажлын явцад хяналт тавьж, шаардлагатай асуудлыг хэлэлцэж чиглэл, зөвлөмж өгөх
5. Судалгааны явц, үр дүнг Эрүүл мэндийн яам, Шинжлэх ухаан, технологийн зөвлөл, Улсын Онцгой Комисс, бусад холбогдох байгууллагуудад танилцуулж, тайлагнана.

Хугацаа: 2021 оны 3-4 улирал